Орчуулга

АНУ-ЫН ДҮҮРГИЙН ШҮҮХ
НЬЮ-ЙОРКИЙН ӨМНӨД ДҮҮРЭГ

BEIJING SHOUGANG MINING INVESTMENT COMPANY LTD., CHINA HEILONGJIANG INTERNATIONAL ECONOMIC & TECHNICAL COOPERATIVE CORP., болон QINHUANGDAOSHI QINLONG INTERNATIONAL INDUSTRIAL CO. LTD., Хүсэлт гаргагчид, – эсрэг – МОНГОЛ УЛС, Хариуцагч.	ШҮҮХИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОН ЗАХИРАМЖ 17 Civ. 7436 (ER)

РАМОС, дүүргийн шүүгч:

Хүсэлт гаргагч Хятадын гурван компани болон хариуцагч Монгол Улс үнэ цэнтэй уул уурхайн тусгай зөвшөөрлийн эрхийг хэн эзэмших талаар арав гаруй жил маргалджээ. Энэ ажиллагаа Монголын шүүхийн тогтолцооноос эхэлж, тус улсын Дээд шүүхэд хүрэн, улмаар Нью-Йорк дахь арбитрын бүрэлдэхүүнд шилжсэн бөгөөд одоогоор энд, Нью-Йоркийн өмнөд дүүргийн шүүхэд үргэлжилж байна. Хятадын компаниуд талуудын хоорондын маргааныг арбитраар шийдвэрлэж болохгүй гэсэн арбитрын бүрэлдэхүүний шийдвэрт de novo буюу бие даасан шинэчилсэн хяналт хийж, уг шийдвэрийг хүчингүй болгон, маргааны үндсэн асуудлыг шийдвэрлүүлэхээр талуудыг арбитрт буцаан оролцуулахыг даалгах хүсэлтийг энэ Шүүхэд гаргасан. Монгол Улс арбитрчдын үндэслэлд хүндэтгэлтэй хандаж, тэдний шийдвэрийг баталгаажуулах эсрэг хүсэлт гаргажээ.

Хятадын компаниуд энэ арбитрыг өөрсдөө эхлүүлж, арбитрын бүрэлдэхүүн харьяалалтай гэж идэвхтэй марган, долоон жил үргэлжилсэн арбитрын ажиллагаанд эрчимтэй оролцсон тул маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэхийг арбитрчид шийдвэрлэх эрхтэйд одоо татгалзал гаргах эрхээсээ татгалзсанд тооцогдоно. Иймд талууд маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэх асуудлыг арбитрын бүрэлдэхүүнд шилжүүлэхээр тодорхой бөгөөд эргэлзээгүй тохиролцсон гэж Шүүх үзэж, арбитрын шийдвэрт хүндэтгэлтэй хандах хязгаарлагдмал хяналт хийсний үндсэн дээр уг шийдвэрийг баталгаажуулж байна. Монгол Улсын хүсэлтийг ХАНГАВ. Хятадын компаниудын хүсэлтийг ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОВ.

I. ҮНДЭСЛЭЛ БОЛСОН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1991 онд Хятад, Монголын Засгийн газрууд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хөрөнгө оруулалтыг

хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрт гарын үсэг зуржээ.[1] Энэхүү хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээр (“BIT”) нь улсууд хөрөнгө оруулалтад тэгш хандахыг зааж, нөгөө улсын компаниудын хөрөнгө оруулалтыг төр албадан хураахыг хориглон, хэлэлцээрийн дагуу аливаа маргаан гарсан тохиолдолд арбитр явуулах нөхцөл, журмыг дэлгэрэнгүй тогтоосон. Хэлэлцээр 1993 онд хүчин төгөлдөр болсон.

Хятадын компаниудын нэг болох Qinhuangdoaoshi Qinlong International Industrial Company Ltd. (“Циньлун”) нь 2002 онд Монголын түнштэй хамтарсан компани байгуулж, Монголын хойд хэсгийн Төмөртэйн бүсэд орших төмрийн хүдрийн ордыг ашиглахаар болсон. Michael A. Granne-ийн мэдүүлгийн А хавсралт (“Арбитрын шийдвэр”), 91 дүгээр догол мөр, баримт бичиг № 1. Нөгөө хоёр компани болох Beijing Shougang Mining Investment Company Ltd. болон China Heilongjiang International Economic & Technical Cooperative Corp. нь 2004 онд Циньлунаас хамтарсан компанийн хувь эзэмшлийг худалдан авчээ. Мөн тэнд, 92 дугаар догол мөр. Монголын түнш нь 2005 онд төмрийн хүдэр экспортлохыг зөвшөөрсөн тусгай зөвшөөрлийг хамтарсан компанид шилжүүлсэн. Мөн тэнд, 90 дүгээр догол мөр.

2006 оны турш Монголын эрх бүхий байгууллагууд хамтарсан компанийн үйл ажиллагааг хянан шалгаж, эцэст нь 9 дүгээр сард тусгай зөвшөөрлийг цуцалжээ. Арбитрын шийдвэрийн 150–176 дугаар догол мөрийг ерөнхийд нь үзнэ үү. Хамтарсан компани 2006 оны 11 дүгээр сард Монголын шүүхэд нэхэмжлэл гаргаж, хэргийг Монгол Улсын Дээд шүүх хүртэл хянуулсан. Мөн тэнд, 179 дүгээр догол мөр. Эцэст нь ашиглалтын тусгай зөвшөөрлөө буцаан авч чадаагүй. Мөн тэнд. Өөр хэд хэдэн компани болон Монголын Засгийн газар оролцсон цогц шүүхийн ажиллагааны дараа 2009 он гэхэд төмрийн хүдрийн ордын тусгай зөвшөөрөл болон газар ашиглах эрх Монголын төрийн өмчит төмөрлөгийн компанид очсон байв. Мөн тэнд, 184, 189 дүгээр догол мөр. Хятадын компаниуд Монгол Улс хөрөнгө оруулалтыг нь албадан хурааж, хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийг зөрчсөн гэж үзэн 2010 оны 2 дугаар сард BIT-ийн 8 дугаар зүйлийн дагуу арбитр эхлүүлсэн. Мөн тэнд, 6, 190 дүгээр догол мөр.

Гурван арбитрчаас бүрдсэн тусгай бүрэлдэхүүнтэй, Арбитрын Байнгын шүүхийн дэмжлэгтэйгээр Нью-Йоркт явагдсан арбитр долоон жил үргэлжилжээ. Хятадын компаниуд 2011 оны 3 дугаар сард нэхэмжлэлийн үндэслэлээ гаргасан. Мөн тэнд, 19 дүгээр догол мөр. Монгол Улс 9 дүгээр сард хариу тайлбар гаргаж, сөрөг нэхэмжлэл дэвшүүлэн, компаниудын

[1] http://tfs.mofcom.gov.cn/aarticle/h/at/201002/20100206778627.html хаягт нийтлэгдсэн. Сүүлд үзсэн огноо 2019 оны 11 дүгээр сарын 15. Бүгд Найрамдах Монгол Ард Улс нь өнөөгийн ардчилсан Монгол Улсын өмнөх, Зөвлөлтийн дагуул улс байсан. Шийдвэрийн 103, 106 дугаар догол мөр.

анхны нэхэмжлэлийг арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэх харьяалалтайд татгалзал гаргасан. Мөн тэнд, 21 дүгээр догол мөр. 2012 оны 6 дугаар сард Хятадын компаниуд Монгол Улсын хариу тайлбарт хариу өгч, сөрөг нэхэмжлэлүүдийг арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэх харьяалалтайд өөрсдөө татгалзал гаргав. Мөн тэнд, 28 дугаар догол мөр. Монгол Улс 2012 оны 12 дугаар сард дахин хариу тайлбар гаргажээ. Мөн тэнд, 34 дүгээр догол мөр. Нотлох баримт гаргуулах ажиллагаа болон нэг арбитрчийг солих шаардлагын улмаас гурван жил завсарласны дараа арбитрын бүрэлдэхүүн 2015 оны 9 дүгээр сард Нидерландад хуралдаан хийсэн. Мөн тэнд, 77 дугаар догол мөр.

Хятадын компаниуд арбитрчид энэ маргааныг хэлэлцэх эрхтэй гэж удаа дараа, идэвхтэй маргасан. Энэ асуудлыг арбитрчид өөрсдөө шийдвэрлэхэд тэд хэзээ ч татгалзал гаргаагүй. Тэд маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэх асуудлыг арбитрт хандах хүсэлтдээ анх бүрэлдэхүүний өмнө тавьсан. Michael A. Granne-ийн мэдүүлгийн B хавсралт, V.3 хэсгийг үзнэ үү. Тус хүсэлтдээ тэд хэлэлцээрийн бичвэр болон зорилгод үндэслэн арбитрын харьяаллыг дэмжсэн үндэслэл гаргажээ. Жишээлбэл, мөн тэнд, 68, 69 дүгээр догол мөрийг үзнэ үү. Нэхэмжлэлийн үндэслэлдээ тэд уг тайлбаруудыг дэлгэрүүлж, бусад олон улсын арбитрын шийдвэрээс нэмж эш татсан. Michael D. Nolan-ийн мэдүүлгийн 1 дүгээр хавсралтын 60–88 дугаар догол мөрийг үзнэ үү. Тэрхүү баримт бичгийн турш компаниуд өөрсдийн үндэслэлийг арбитрчдад илэрхий “гаргаж тавьсан” бөгөөд маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэх асуудлыг тэд хэлэлцэхэд татгалзал гаргаагүй. Жишээлбэл, мөн тэнд, 61 дүгээр догол мөрийг үзнэ үү (“Нэхэмжлэгчид Хэлэлцээрийн хам сэдэв болон түүний зорилго, зориулалтыг харгалзан 8(3) дугаар зүйлийн ердийн утгыг Арбитрын бүрэлдэхүүн харьяалалтай гэсэн агуулгаар л тайлбарлах боломжтой гэж үзэж байна . . . .”). Дараа нь компаниуд нэхэмжлэлийн үндэслэлээ ирүүлснээс хэдэн сарын дараа болсон ажиллагааны хуралдаанд талууд харьяалал болон маргааны үндсэн асуудлыг тусгаарлалгүй, нэгэн зэрэг шийдвэрлэхээр тохиролцсон. Мөн тэнд, 16 дугаар догол мөр. Үүний дараа Монгол Улс хариу тайлбартаа харьяаллын талаарх үндэслэлүүдэд хариулахад компаниуд арбитрчид харьяаллын маргааныг хэлэлцэх эрхтэйд татгалзал гаргалгүйгээр дахин хариу өгсөн. Michael D. Nolan-ийн мэдүүлгийн 3 дугаар хавсралтын 43–48 дугаар хуудсыг үзнэ үү.

Арбитрын бүрэлдэхүүн 2017 оны 6 дугаар сард шийдвэрээ гаргажээ. Хятадын компаниуд BIT-ийн дагуу арбитрын нэхэмжлэл гаргах эрхтэй гэж тогтоосныхоо дараа, Арбитрын шийдвэрийн 442 дугаар догол мөр, бүрэлдэхүүн BIT нь арбитрчдад төлөх нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохоос гадна хөрөнгө албадан хураасны төлөө төр хариуцлага хүлээх эсэхийг шийдвэрлэх эрх олгож байгаа эсэхэд дүн шинжилгээгээ төвлөрүүлсэн. Мөн тэнд, 423 дугаар

догол мөр (мөн тэндхийн 252–268 дугаар догол мөрд дурдсан Монгол Улсын үндэслэлүүдийг эш татсан). Арбитрын бүрэлдэхүүн BIT-ийн холбогдох заалтын ердийн утгыг түүний хам сэдэв болон зорилго, зориулалттай нь уялдуулан тайлбарлахаас эхэлсэн. Мөн тэнд, 424 дүгээр догол мөр (Олон улсын гэрээний эрх зүйн тухай 1969 оны Венийн конвенцын 31(1) дүгээр зүйлийг эш татсан).[2] Хэлэлцээрийн бүтцэд үндэслэн арбитрын харьяаллын бүх хүрээг BIT-ийн 8(3) дугаар зүйл, тодруулбал "хөрөнгө албадан хураасны нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргаан" гэсэн хэллэг тодорхойлж байна гэж үзсэн. Мөн тэнд, 436 дугаар догол мөр.

Дараа нь арбитрын бүрэлдэхүүн уг хэллэгийн утгад анхаарлаа хандуулж, түүнд орсон үгсийн ердийн утга болон хэлэлцээрийн бүтцэд эзлэх байр суурийг нь авч үзсэн. Арбитрын шийдвэрийн 438–445 дугаар догол мөр. Энэ хэллэг нь анхнаасаа нөхөн төлбөр төлөх үүрэг үүссэн эсэх тухай маргааныг бус, нэгэнт төлсөн нөхөн төлбөр хангалттай байсан эсэх тухай маргааныг шийдвэрлэхээр арбитрын харьяаллыг хязгаарлаж байна гэж тогтоожээ. Мөн тэнд, 445 дугаар догол мөрийг үзнэ үү. Ийм тайлбар хийвэл уг заалт эрх зүйн аливаа үр нөлөөгүй болно гэж үзсэн бусад арбитрын бүрэлдэхүүн болон Сингапурын Давж заалдах шатны шүүхийн эсрэг дүгнэлтүүдээс тухайн хэргийг ялган тайлбарлаж, өөрийн шийдвэрийг үндэслэсэн. Мөн тэнд, 447–448 дугаар догол мөр. Ингэхдээ Засгийн газар хөрөнгө албадан хураасныг шууд зарласан эсхүл Монголын шүүхээр дамжуулан шууд бусаар тогтоосны дараа арбитр эхлүүлж болохыг тэмдэглэжээ. Мөн тэнд, 448–449 дүгээр догол мөр. Ийм журам нь Хятад, Монгол BIT-ийг хэлэлцэн тохиролцохдоо хийсэн сонголт бөгөөд BIT-ийн зорилго, зориулалттай нийцнэ гэж үзсэн. Мөн тэнд, 450–451 дүгээр догол мөр. Энэ дүн шинжилгээнд үндэслэн Хятадын компаниудын нэхэмжлэл болон Монгол Улсын сөрөг нэхэмжлэлийн аль алиныг шийдвэрлэх харьяалалгүй гэж үзэж, арбитрыг дуусгасан. Мөн тэнд, 477 дугаар догол мөр.

II. ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙ

Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахыг хүссэн тал ердийн нөхцөлд маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэх асуудлыг, тухайлбал тухайн маргаан арбитрын заалтын хамрах хүрээнд багтах эсэхийг шүүхээр de novo журмаар хянуулахыг хүсэж болно. Schneider v. Kingdom of Thailand, 688 F.3d 68, 71 (2d Cir. 2012)-ийг үзнэ үү (Howsam v. Dean Witter Reynolds, Inc., 537 U.S. 79, 83 (2002)-ыг эш татсан). Харин талууд маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэх асуудлыг мөн арбитраар шийдвэрлүүлэхээр тохиролцсон "тодорхой бөгөөд эргэлзээгүй нотолгоо" байгаа бол шүүх арбитрын бүрэлдэхүүний уг шийдвэрийг бусад

[2] https://treaties.un.org/doc/Treaties/1980/01/19800127%2000-52%20AM/Ch_XXIII_01.pdf хаягт нийтлэгдсэн. Сүүлд үзсэн огноо 2019 оны 11 дүгээр сарын 18.

арбитрын шийдвэрийн нэгэн адил хүндэтгэлтэй хандах зарчмаар хянах ёстой. First Options, 514 U.S. 938, 943–44 (1995)-ыг үзнэ үү.

Арбитрын шийдвэрт хүндэтгэлтэй хандах хяналт хийх үед түүнийг хүчингүй болгохыг зөвшөөрөх хязгаарлагдмал үндэслэлүүдийг Холбооны арбитрын тухай хууль ("FAA"), 9 U.S.C. § 10, мөн гадаадын этгээд оролцсон арбитрын шийдвэрийн хувьд 1958 оны 6 дугаар сарын 10-ны Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенцын ("Нью-Йоркийн конвенц") V зүйлд заасан.[3] АНУ-д гаргасан, гадаадын этгээд оролцсон арбитрын шийдвэрийг шүүх FAA эсхүл Нью-Йоркийн конвенцын аль нэгэнд заасан үндэслэлээр хүчингүй болгож болно. Zurich Am. Ins. Co. v. Team Tankers A.S., 811 F.3d 584, 588 (2d Cir. 2016)-ыг үзнэ үү; мөн Yusuf Ahmed Alghanim & Sons v. Toys "R" Us, Inc., 126 F.3d 15, 23 (2d Cir. 1997)-ыг үзнэ үү ("[Нью-Йоркийн] конвенц нь . . . арбитрын шийдвэр гарсан улс өөрийн дотоодын арбитрын эрх зүй болон хамгаалалт олгох илэрхий, далд бүх үндэслэлийн дагуу уг шийдвэрийг хүчингүй болгох эсхүл өөрчлөх эрх чөлөөтэй байхыг тусгайлан тооцсон").

Арбитрын шийдвэрийг баталгаажуулах ажиллагаа нь ихэвчлэн арбитрын эцсийн шийдвэрийг шүүхийн шийдвэр болгодог хялбаршуулсан ажиллагаа байдаг. D.H. Blair & Co., Inc. v. Gottdiener, 462 F.3d 95, 110 (2d Cir. 2006). Уг шийдвэрийг хүчингүй болгоогүй, өөрчлөөгүй эсхүл залруулаагүй бол шүүх баталгаажуулах үүрэгтэй. Мөн тэнд (9 U.S.C. § 9-ийг эш татсан). Арбитрын шийдвэрийг баталгаажуулсан шүүхийн шийдвэр гаргуулах хүсэлтийг "хүсэлтийн хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, ингэснээр арбитрын шийдвэрийг шүүхээр албадан биелүүлэх эсхүл түүнд засвар өөрчлөлт оруулахад ердийн үед шаардагдах гэрээний тусдаа нэхэмжлэл гаргах шаардлагыг арилгадаг". Hall St. Assocs., L.L.C. v. Mattel, Inc., 552 U.S. 576, 582 (2008).

III. АРБИТРЫН ШИЙДВЭРИЙГ ХЯНАХАД ШҮҮХЭЭС ХЭРЭГЛЭХ ШАЛГУУР

Шүүх арбитрын үндэслэл болсон хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийг болон арбитрын бүрэлдэхүүний өмнө талуудын гаргасан үйлдлийг хянаж үзэв. Хэлэлцээрт өөрт нь маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэх асуудлыг арбитрчдад шилжүүлэхийг талууд зорьсны тодорхой бөгөөд эргэлзээгүй нотолгоо байхгүй боловч Хятадын компаниудын арбитрын явцад гаргасан үйлдэл ийм нотолгоо болж байна гэж Шүүх үзэв.

Хэлэлцээрт аливаа асуудлыг арбитраар шийдвэрлэж болох эсэхийг ямар байгууллага шийдвэрлэх талаар илэрхий тохиролцоо байхгүй. Илэрхий тохиролцоо байгааг нотлохын тулд

[3] http://www.newyorkconvention.org/english хаягт нийтлэгдсэн. Сүүлд үзсэн огноо 2019 оны 11 дүгээр сарын 18.

Монгол Улс 8(5) дугаар зүйлийн эхний өгүүлбэр болох “Арбитрын бүрэлдэхүүн өөрийн ажиллагааны журмыг тогтооно” гэсэн заалтыг зааж байна. Үүнийг арбитрын бүрэлдэхүүнд өргөн эрх хэмжээ олгосон гэж тайлбарлахыг Монгол Улс Шүүхээс хүссэн. Шүүх энэ саналыг хүлээн авахгүй.

> “Ажиллагааны журам” гэсэн үгийн ердийн утгад харьяаллыг нарийвчлан тогтоосон дүрэм багтахгүй. Black’s Law Dictionary уг нэр томьёог “Тодорхой арга эсхүл үйл ажиллагааны дараалал”, мөн “Иргэний нэхэмжлэл эсхүл эрүүгийн яллах ажиллагааг явуулах шүүхийн дүрэм буюу арга хэлбэр” гэж тодорхойлдог. Procedure, Black’s Law Dictionary (11 дэх хэвлэл, 2019). Үүний нэгэн адил Дүрэм батлах эрх олгох тухай хууль, 28 U.S.C. § 2072 нь Дээд шүүхэд “шүүхийн практик, ажиллагааны нийтлэг дүрэм батлах” эрх олгодог боловч шүүхүүдийн харьяаллыг тогтоох эрх олгодоггүй. Тэр асуудлыг АНУ-ын Үндсэн хууль болон 28 U.S.C. §§ 1330 ба дараах зүйлүүд тусад нь зохицуулдаг.

Түүнчлэн АНУ-ын шүүхүүдийн тайлбарласнаар маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэх асуудлыг арбитрчдад даалгасан бусад арбитрын хэлэлцээр үүнийг өөр байдлаар зохицуулсан байдаг. Жишээлбэл, АНУ, Эквадорын хоорондын BIT уг асуудлыг арбитрын бүрэлдэхүүнд даалгасан эсэхийг Хоёрдугаар тойргийн шүүх хэлэлцсэн. Republic of Ecuador v. Chevron Corp., 638 F.3d 384, 394 (2d Cir. 2012)-ыг үзнэ үү. Арбитрч “өөрийн харьяалалгүй гэсэн татгалзал, түүний дотор . . . арбитрын хэлэлцээр байгаа эсэх эсхүл хүчин төгөлдөр эсэхтэй холбоотой аливаа татгалзлыг шийдвэрлэх эрхтэй” гэж заасан НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын (“UNCITRAL”) Арбитрын дүрмийг хэрэглэхээр тохиролцсоноор улсууд бүрэлдэхүүнд ийм эрх олгосон гэж тус шүүх үзсэн. Мөн тэнд. Монгол, Хятадын BIT-д маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэхийг тогтоох асуудлыг арбитрчдад даалгасныг тодорхой болгох үүнтэй адил үг хэллэг байхгүй. Мөн Schneider v. Kingdom of Thailand, 688 F.3d 68, 73 (2d Cir. 2012)-ийг (компани болон Тайландын хоорондын арбитрын нөхцөлд UNCITRAL-ын дүрмийг эшилсэн заалтыг хэрэглэсэн); Contec Corp. v. Remote Solution Co., 398 F.3d 205, 208 (2d Cir. 2005)-ыг (дотоодын арбитрын хэлэлцээрт Америкийн арбитрын холбооны дүрмийг эшилсэн заалтыг хэрэглэсэн) үзнэ үү.

Харин Монгол Улс Хятадын компаниуд арбитрын явц дахь үйлдлээрээ маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэх асуудлыг арбитрчид авч үзэхийг хүлээн зөвшөөрсөн гэж голлон маргаж байна. Тодруулбал, Хятадын компаниуд арбитрыг өөрсдөө эхлүүлсэн, хамгийн анхны баримт бичигтээ арбитраар шийдвэрлэж болохыг дэмжсэн үндэслэл гаргасан, мөн уг асуудлыг хэлэлцэх явцад арбитрчид түүнийг авч үзэхэд огт татгалзал гаргаагүй гэж Монгол Улс

тайлбарлажээ. Компаниуд өөрсдийн үйлдэл First Options, 514 U.S. 938, 944 (1995)-д тодорхойлсон “тодорхой бөгөөд эргэлзээгүй нотолгоо”-ны түвшинд хүрэхгүй гэж маргаж байна.

First Options хэрэгт Дээд шүүх үндсэн арбитрын ажиллагааны хариуцагчдын гаргасан арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах хүсэлтийг хэлэлцжээ. Мөн тэнд, 940–941. Арбитрын ажиллагааны явцад хариуцагчид арбитрын хэлэлцээрт хэзээ ч гарын үсэг зураагүй гэсэн үндэслэлээр арбитрчдын харьяаллыг эсэргүүцсэн ганц тайлбар ирүүлэх байдлаар л оролцсон. Мөн тэнд, 941. Арбитр дууссаны дараа хариуцагчид холбооны шүүхэд эрхээ хамгаалуулахаар хандаж, маргааныг арбитраар шийдвэрлэж болно гэсэн арбитрчдын шийдвэрт de novo хяналт хийхийг хүссэн. Мөн тэнд. Тэдний хязгаарлагдмал оролцоог харгалзан, хариуцагчид маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэхийг арбитрч шийдвэрлэх эрхтэйг хүлээн зөвшөөрөөгүй гэж Дээд шүүх дүгнэж, доод шатны шүүхийн de novo хяналтыг хэвээр үлдээжээ. Мөн тэнд, 946.

First Options хэргийн үйл баримт энэ хэргийнхээс эрс ялгаатай. First Options-ийг хэлэлцсэн Шүүхийн өмнө ямар ч арбитрын хэлэлцээр огт байгуулагдаагүй гэж эсэргүүцсэн хариуцагчид байсан. Харин энэ хэрэгт BIT байгаа эсэхэд маргаангүй. First Options-ийн арбитрын хариуцагчид маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэхийг эсэргүүцсэн ганц тайлбараар л оролцсон. Хятадын компаниуд үндсэн арбитрт долоон жилийн турш эрчимтэй оролцжээ.

Гэхдээ энэ хэргийг хамгийн ихээр ялгаж буй хүчин зүйл нь компаниуд арбитрыг өөрсдөө эхлүүлж, хамгийн анхны баримт бичгээсээ эхлэн арбитрчдын харьяаллыг дэмжсэн үндэслэл гаргасан явдал юм. First Options-ийн арбитрын хариуцагчдаас ялгаатай нь Хятадын компаниуд энэ арбитрыг хаана, хэрхэн, ямар үндэслэлээр эхлүүлэхээ сонгох боломжтой байсан. Шүүхэд хандаж арбитр явуулахыг даалгуулахын оронд тэд анхнаасаа асуудлуудыг арбитрчдад шилжүүлсэн. Ийм үйлдэл нь эрхээсээ татгалзсанд тооцогдоно. Opals on Ice Lingerie v. Bodylines Inc., 320 F.3d 362, 368 (2d Cir. 2003)-ыг үзнэ үү (“[Х]эрэв тал маргааныг арбитрт шилжүүлэхэд хугацаанд нь татгалзал гаргалгүйгээр арбитрын ажиллагаанд оролцвол уг тал арбитрыг эсэргүүцэх эрхээсээ татгалзсан гэж үзэж болно”).

Энэ дүүргийн шүүгч Маррерогийн 2007 онд хэлэлцсэн In re Arbitration between Halcot Navigation Ltd. Partnership and Stolt-Nielsen Transp. Group, 491 F. Supp. 2d 413 (S.D.N.Y. 2007) хэргийн үр дүн Шүүхийн энэ үндэслэлийг бататгана. Тэр хэрэгт арбитрын хариуцагч бүрэлдэхүүнд хүсэлт гаргаж, маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэх асуудлыг уг бүрэлдэхүүн хэлэлцэхийн тулд талуудаас бичгээр тайлбар авахыг хүссэн. Мөн тэнд, 417. Арбитрын шатанд татгалзал гаргахаас татгалзсаныхаа дараа арбитрын бүрэлдэхүүний харьяаллын шийдвэрийг дүүргийн шүүхээр хянуулахыг оролдсон нь “өөртөө аль ч тохиолдолд ашигтай үр дүн бий болгож, хоёр талаас ашиг хүртэх арга болгон маргааныг арбитраар

шийдвэрлэж болох эсэх асуудлыг арбитрчдаар шийдвэрлүүлэхээр явуулан, [хариуцагчид] ашигтай бол үр дүнг нь зөвшөөрч, ашиггүй бол татгалзан уг асуудлаар шүүхэд маргах" явдал гэж шүүгч Mappero үзжээ. Мөн тэнд, 419; мөн Cleveland Elec. Illuminating Co. v. Utility Workers Union of America, 440 F.3d 809, 813 (6th Cir. 2006)-ыг үзнэ үү (арбитрын бүрэлдэхүүн маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэхийг шийдвэрлэх эрхтэйд татгалзал гаргаагүй нь холбооны шүүхийн хяналтын үед уг үндэслэлийг гаргах эрхээс татгалзсанд тооцогдоно гэж үзсэн).

Halcot-ийн үндэслэл энэ хэрэгт бүр ч илүү хүчтэй үйлчилнэ. Хятадын компаниуд анхны хүсэлтдээ маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэхийг арбитрчдаар шийдвэрлүүлэх хүслээ илэрхий гаргаж тавьсан бөгөөд дор хаяж гурван албан ёсны баримт бичигтээ уг үндэслэлүүдийг дэлгэрүүлсэн. Мөн хамгийн анхны ажиллагааны хуралдаанд харьяаллыг маргаантай нэгэн зэрэг шийдвэрлэхээр тохиролцсон. Бүх ажиллагааг эхлүүлж, харьяаллын асуудлын хүрээг тогтоон, долоон жил оролцож, нэг ч удаа татгалзал гаргаагүй атлаа компаниуд одоо АНУ-ын шүүхэд ирээд энэ нь арбитрчдын шийдвэрлэх асуудал байгаагүй гэж шаардаж болно гэж үзэх боломжгүй.

Иймд маргааныг арбитраар шийдвэрлэж болох эсэх асуудлыг арбитрын бүрэлдэхүүнд тодорхой бөгөөд эргэлзээгүй шилжүүлсэн гэж Шүүх үзэв. Шүүх одоо арбитрын шийдвэрт хүндэтгэлтэй хандах хязгаарлагдмал хяналт хийнэ.

IV. АРБИТРЫН ШИЙДВЭРИЙГ ХЯНАСАН НЬ

Шүүх de novo хяналт хийхээс татгалзсан тохиолдолд арбитрын шийдвэрийг хүчингүй болгох бие даасан үндэслэл болох FAA эсхүл Нью-Йоркийн конвенцын ямар нэг заалтыг Хятадын компаниуд хүсэлтийг дэмжсэн баримт бичигтээ заагаагүй. Мөн Нью-Йоркийн конвенцын аль нэг үндэслэл эсхүл FAA-ийн 10(a)(4) дэх хэсгийн дагуу шийдвэрийг хүчингүй болгохыг эсэргүүцсэн Монгол Улсын үндэслэлүүдэд компаниуд тусгайлан хариулаагүй. Иймээс тэд уг үндэслэлүүдийг гаргах эрхээсээ татгалзсан гэж Шүүх үзэж болох байв. Brown v. City of New York, 862 F.3d 182, 187 (2d Cir. 2017)-г үзнэ үү ("Анхан шатны шүүхийн ажиллагааны асуудлаар хэрэгжүүлж болох үзэмжийн эрх нь аливаа үндэслэл гаргах эрхээс татгалзсан эсэхийг шийдвэрлэхэд мөн хамаарна").

Гэсэн ч Шүүх арбитрчдын шийдвэрийн зөв эсэхтэй холбоотой компаниудын тайлбаруудыг FAA-ийн 10(a)(4) дэх хэсгийн дагуу арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах хүсэлт гэж тайлбарлан авч үзнэ. Тус хэсэг нь арбитрчид "эрх хэмжээгээ хэтрүүлсэн эсхүл арбитрын шийдвэр утга учиргүй болох хэмжээнд эрх мэдлээ хэтрүүлсэн" тохиолдолд шийдвэрийг хүчингүй болгохоор заасан. Энэ үндэслэлээр арбитрын шийдвэрийг хүчингүй болгох ёстойг

Шүүхэд нотлох Хятадын компаниудын үүргийн босго өндөр бөгөөд арбитрын бүрэлдэхүүний шийдвэр нь арбитраар шийдвэрлүүлэх тохиролцооноос “мөн чанараа олж аваагүй” болохыг харуулах шаардлагатай. ReliaStar Life Ins. Co. of N.Y. v. EMC Nat. Life Co., 564 F.3d 81, 85 (2d Cir. 2009)-ыг үзнэ үү. Эс бөгөөс “гарсан үр дүнг зөвтгөх өчүүхэн ч гэсэн боломжит үндэслэл” байгаа цагт Шүүх арбитрын шийдвэрийг хэвээр үлдээнэ. Мөн тэнд, 86 (доторх эшлэлийг хасав).

Дээр дэлгэрэнгүй дурдсан арбитрын бүрэлдэхүүний дүн шинжилгээ нь энэ Шүүхийн хэрэглэж буй, арбитрын шийдвэрт хүндэтгэлтэй хандах хязгаарлагдмал хяналтын шалгуурыг хангалттай давж байна. Тэр дүн шинжилгээ зөв эсэх талаар Шүүх байр суурь илэрхийлэхгүй. Мөн тэнд, 86-г үзнэ үү (шүүхүүд “арбитрчид асуудлыг зөв шийдсэн эсэхийг авч үзэх ёсгүй” гэж анхааруулсан; доторх эшлэл болон өөрчлөлтийг хасав). Харин арбитрчдын харьяаллынхаа талаар өгсөн олон үндэслэл нь зүгээр боломжит үндэслэл төдий хэмжээнээс хавьгүй давсан бөгөөд дүн шинжилгээ нь бараг бүхэлдээ хэлэлцээрийн бичвэрт тулгуурласан учраас түүний мөн чанараас үүдэн гарсан нь эргэлзээгүй гэж Шүүх үзэв.

V. ДҮГНЭЛТ

Дээрх үндэслэлээр Хятадын компаниудын арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах хүсэлтийг ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОЖ, арбитрын шийдвэрийг баталгаажуулах тухай Монгол Улсын эсрэг хүсэлтийг ХАНГАСУГАЙ. Шүүхийн нарийн бичгийн даргад хэргийг хаахыг даалгасугай.

ИЙНХҮҮ ЗАХИРАМЖИЛСУГАЙ.
Огноо: 2019 оны 11 дүгээр сарын 19
Нью-Йорк, Нью-Йорк муж
[Гарын үсэг]
Эдгардо Рамос
АНУ-ын дүүргийн шүүгч